



## Нуруу нугасны багц шинжилгээний бэлтгэл

### **Цусны шинжилгээний бэлтгэл:**

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 24 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа хэрэглээгүй, өөх тос ихтэй хоол идээгүй байх , биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.
- Цусны шинжилгээ өгөхөөс өмнө 15 минут орчим тайван суух хэрэгтэй.
- Цус өгөхийн өмнө эхо, дуран, рентген зэрэг багажийн шинжилгээнд ороогүй, судсаар тодосгогч бодис хэрэглээгүй байна.

### **Ясны сийрэгжилтийн шинжилгээ:**

- Хөлийн өсгий ясанд хийгддэг учир тирко өмсөхгүй, тайлахад хялбар байхаар оймс өмсөж ирнэ үү.

### **Рентген шинжилгээ:**

- Нурууны зургийг янз бүрийн байрлалаар авах ба зургийг MRI шинжилгээтэй харьцуулан дүгнэх тул та рентген шинжилгээг хийлгэсэн байвал зохино.
- Хэрвээ та жирэмсэн бол рентген шинжилгээ хийлгэхээс зайлсхийх хэрэгтэй.
- Шаардлагатай тохиолдолд сувилагчид хэлж хамгаалалтын хормогч зүүх хэрэгтэй.

### **Соронзон резонанст томографи:**

Соронзон резонанст томографийн шинжилгээг хийхэд битүү орчинд, хэвтээ байрлалд хөдөлгөөнгүй байдлаар байх ба шинжилгээний явц 30–40 минут орчим үргэлжилдэг. Шинжилгээг хийх явцад танд их хэмжээний дуу чимээ сонсогдох тул чихээндээ бөглөөс хийж орно уу. Уг багцад бүтэн нурууны /хүзүүнээс эхлээд ахар сүүл хүртэл/ MRI багтсан ба шинжилгээ 1 цаг орчим үргэлжилнэ. Хэрвээ танд битүү орчинд удаан байхад амьсгал давчдах, бачимдах зэрэг таагүй мэдрэмж төрвөл хариуцсан ажилтанд мэдэгдэнэ. Бусад дэлгэрэнгүй зааврыг шинжилгээнд орохын өмнө танилцуулах болно.

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.

Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%-ийн хөнгөлөлт эдлүүлнэ.